



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.mn, http://www.moh.mn

2015.11.17 № 2/4630

тапай _____ -ны № _____ -т

Г Т

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНД,
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ

Салбарын хэмжээнд сахилга хариуцлага, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх талаар гарсан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 449 дүгээр тушаалыг хавсралтаар хүргүүлж байна. Уг тушаалыг харьяа байгууллага, нэгж, сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэн, хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг хүсье.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАТ-ЭРДЭНЭ



088271



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2015 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 449

Улаанбаатар хот

Г

Г

**Сахилга, дэг журам, үйлчилгээг
сайжруулах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 2 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7-р зүйлийн 7.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын салбарын удирдлагын хүрээнд үүссэн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан салбарын хэмжээнд сахилга хариуцлага, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг сайжруулах, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллахыг ЭМСЯ-ны харьяа эрүүл мэнд, спортын байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газрын дарга /захирал/ нарт үүрэг болгосугай.

1.1 Хүн амд эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд өдөр тутмын удирдлагаар хангах, үйлчлүүлэгчдэд хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, чирэгдэлгүй үйлчилж, үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа хандлагыг эрчимтэй сайжруулах.

1.2 Эрүүл мэндийн ажилнуудын сахилга, хариуцлагыг эрс сайжруулан ажлын цагийг чанд баримталж, үйлчлүүлэгчдийг чирэгдүүлдэг хүлээлгэдэг зөрчлийг гаргахгүй байх, зөрчил гаргасан тохиолдолд тухай бүрт нь хариуцлага тооцох, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйд хяналт тавин, түүнийг мөрдүүлэн ажиллах.

1.3 Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын өмч, хөрөнгө төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зарцуулалтыг зохих хугацаанд нь тайлagnаж, төсвийн сахилга хариуцлагыг чандлан сахиж ажиллах.

1.4 Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн дагуу холбогдох үйл ажиллагааныхаа мэдээллийг нийтэд ил тод болгон байршуулах, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавьж байх.

1.5 Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг байгууллагынхаа хэмжээнд тодорхой төлөвлөгөө хуваарийн дагуу зохион байгуулж, “Авлигагүй-хүнд сурталгүй-шуурхай үйлчилгээтэй хамт олсон” болж ажиллах.

1.6 Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтэд анхааралтай хандаж, хуулийн хугацаанд нь хариуг нь өгч, санал гомдлын мөрөөр тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох.

1.7 Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний стандартыг мөрдүүлж, эмч, ажилтнуудыг алдаа, эндэгдэлгүй ажиллуулах бүхий л нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.8 Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах хэрэглэгчийн төлөө ажилладаг ТББ иргэдтэй хамтран ажиллах, тэдний туслалцаа дэмжлэгийг авах ажлыг санаачлан зохион байгуулах.

1.9 Байгууллагын хэмжээнд дотоод хяналт-шалгалтын ажлыг системтэй зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилган, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага ногдуулах, эмнэлгийн тусlamж үйлчилгээнд сахилга хариуцлагыг чандлан сахиулах.

2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг тодорхой хуваарийн дагуу шалган дүнг 2015 оны 12 дугаар сард багтаан танилцуулахыг ЭМСЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ц. ОЮУНБААТАР